

***Чандмань-өндөр сумын
Соёлын төвийн үйл
ажиллагааны товч
тайлан***

Тус сумын Соёлын төв, спортын төв нь төр засгийн соёлын бодлого, орон нутгийн уламжлалт соёл онцлог, байгууллагын зорилго, зорилтоо биелүүлэх, иргэдийнхээ эрэлт хэрэгцээнд тулгуурласан шинэлэг ажил, уламжлалт ажлуудыг төлөвлөгөө гарган сумын Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Соёлын төв нь нийт 9 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.



Угийн бичгийн хөтлөлтийн талаар

Иргэдийн угийн бичиг хөтлөлтийн талаар сумын үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу тусгагдсан угийн бичиг хөтлөх арга зүйн талаар аймгийн БСУГ-ийн мэргэжилтэн Х.Баасансүрэнг урьж авчирч 2 өдрийн 5 удаагийн сургалтанд 110 иргэд, ажилтан албан хаагчид, ИХТөлөөлөгчид, ахмадууд хамрагдав. Үүний үр дүнд

Аймгийн БСУГ-ын төлөвлөгөөнд орсны дагуу Алунгоо хатны баяраар Угийн бичгийн үзэсгэлэн гаргав. Уг үзэсгэлэнд 35 өрхийн угийн бичиг оролцсоноос Чандмань-Өндөр сумын 3-р багийн иргэн Б.Хишигдэлгэр Тэргүүн байр эзлэж Цомын эзэн , Соёлын ажилтан З.Тунгалаг Дэд байрыг , ахмад настан Н.Буяндэлгэр Гутгаар байрыг тус тус эзэлсэн.

Угийн бичиг хөтлөлт одоогийн байдлаар сумын хэмжээнд хийсэн ургийн баяр, өрхийн угийн бичиг хөтлөлтөөрөө 30 хувьтай байна

. Нийт багуудын хэмжээнд угийн бичгийн сургалтыг 6 сард багтаан хийхээр өвийн ажилтны төлөвлөгөөнд тусгагдсан.

. ИТХ-тай хамтран ажиллах ажлын төлөвлөгөөнд тусгаж өгсөн байгаа.

Угийг бичгийн сургалтыг явуулахад төсөв хөрөнгө дутмаг , сургалтын хэрэглэгдэхүүн болон сургагч багш бэлтгэх шаардлагатай байна.

ИРГЭДИЙН СОЁЛЫН ТҮВШИНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

Соёлын төвөөс зохион байгуулсан ажил үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэд, үйлчлүүлэгчдэд арга хэмжээ эхлэхийн өмнө болон үйл ажиллагааны дундуур үзвэр үйлчилгээний соёл, соёлтой үйлчлүүлэх, хүнтэй зөв боловсон, соёлтой харилцах харилцааны талаар яриа танилцуулга хийж байснаар одоогийн байдлаар үзвэр үйлчилгээнд орж гарахдаа зөв соёлтой тасалбараа авч сурсан, харилцаа хандлага ёс зүйн түвшин өөрчлөгдсөн ба үзэгчдийн заалны сандлын эхний 2 эгнээг ахмад настнуудад тавьж хэвшсэн, үзвэр үзэхдээ хашгирч, шүгэлдэхгүй, үдэшлэг уулзалтанд орохдоо гадуур хувцас тайлж, малгайгүй оролцох зэрэг үйлчлүүлдэг болсон байна.

- ▶ Соёлын төвийн ажилчид болон ардын авьяастнууд, хүүхдүүдтэй хамтарсан урлагийн тоглолтыг өөрийн тайзнаа болон тойргийн сумд, жуулчны баазуудад 12 удаа тоглож 1164 үзэгчдийн хүртээл болгосон.
- ▶ Суманд ирж буй гадны 8 тоглолтонд 1224 үзэгчид хамрагдсан.
- ▶ Соёлын төвөөс зохион байгуулж байгаа цэнгээнт бүжгийн 47 удаагийн үйл ажиллагаанд 3478 хүн үйлчлүүлсэн.
- ▶ Түүхэн болон тэмдэглэлт баяр ёслолын арга хэмжээ 18 удаа зохион байгуулагдаж 2926 гадаад, дотоодын жуулчид, орон нутгийн иргэд хамрагдсан байна.
- ▶ Нийтийн номын сангаас зохион байгуулсан соёл олон нийтийн ажлын 13 арга хэмжээнд нийт 1447 хүн хамрагдлаа.
- ▶ Соёлын төвөөс зохион явуулж байгаа дугуйлан, секц 12 удаа явагдаж 320 хүүхэд хамрагдсан байна.

- ▶ Соёлын төвийн харьяа Спорт зааланд 25 удаагийн арга хэмжээ зохион байгуулагдаж 1351 иргэн оролцсон байна.
- ▶ Соёлын төв болон спорт заал, номын сангуудад явагдсан 18 удаагийн сургалт, семинар, уулзалт , зөвлөгөөнд 3140 хүн хамрагдсан байна.
- ▶ Соёлын төвд явагдсан 153 үйл ажиллагаа, арга хэмжээнүүдэд нийт 15050 хүн хамрагдсан байна.
- ▶ Нийтийн номын сангаар үйлчлүүлсэн 269 уншигч, 2283 ирэгсэд нийт 2552 үйлчлүүлэгчдэд 3376 номыг танхимаар, гэрээр, зөөврөөр тус тус өгч үйлчилсэн байна.
- ▶ Соёлын төвийн өөрийн үйл ажиллагаа нь өнгөрсөн онд шимтгэл, спорт заалны орлого нийт 3.894.300 төгрөгийн орлого олж 1 сая төгрөгөөр Караоке машин худалдан авч, хандивын тоглолтын орлого 915.500 төгрөгийг / У.Жавхланд-300.000төг, М.Энхжаргалд-300.000төг, Б.Цэрэнбатад-315.500төг/-ийг тус тус хандивласан бөгөөд 1.978.800 төгрөгийн орлого тушаасан байна.

Нутаг орныхоо өв соёлыг хойч үедээ өвлүүлэн зааж сургах үүднээс “Нутгийн аялгуу” урлагийн тоглолтыг ардын авяастнуудтайгаа хамтран аймгийн Мөрөн телевизийн бичлэг хийлгэн сиди дээр буулгаж ОНС танхимын архивт хадгаллаа.

Авьяаслаг монголчууд шоунд МУСТА Ц.Чагцалмааг мөнгөн урамшуулал нэг талын замын зардал зэрэгт дэмжин урианхай уртын дуугаар бэлтгэл хийлгэж шүүгчдийн шатны шалгаруулалт хүртэл амжилттай оролцуулж, хойч үедээ өв соёлоо өвлүүлэн үлдээх, орон нутгаа сурталчлах зорилгоор дэмжин ажиллаа.

Малчид дуулж байна улсын уралдаанд залуу уран бүтээлч Б.Түвшинбаярын бэлтгэлийг хангуулж 2-р шат хүртэл нь амжилттай оролцуулж нэг талын зардал буюу мөнгөн тусламж үзүүлсэн. Мөн Уяачид дуулж байна улсын хоёрдугаар уралдаанд Түвшинбаяр, Батжаргал нар оролцсон нь залуучуудын соёл урлагийн үйл ажиллагаанд оролцох идэвх хандлага сайжирч, тэднийг хөгжүүлэх боломж болоцоогоор ханган дэмжин ажиллсан.

Ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд дундын хуримтлалын сан байгуулж ажилчдадаа 318000 төгрөгийн цахилгаан бараа болон төрсөн өдрөөр нь бэлэг авч өгдөг. Үүний үр дүнд ажилчдын ажиллах үйл ажиллагаа сайжирсан

“Алунгоо хатны үр сад” аялан тоглолтоо Цагаан-Үүр, Эрдэнэбулган, Тариалан, Тосонцэнгэл, Түнэл, Алаг-Эрдэнэ сумаар болон хөдөөгийн 4 багаар тоглож 1000 гаруй үзэгчдэд үйлчлэн, Алунгоо хатны баяртаа 500,000 төгрөгийг хандивлан, соёлын төвдөө Караоке машиныг худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Ахмадуудын дунд төрөл бүрийн арга хэмжээг сар бүр зохион явуулдаг тул ахмадууд маш их өндөр сэтгэгдэлтэй байдаг.

- * Хэн нь азтай вэ? хөгжөөнт тоглоом

- * Монгол хоолоо хэн сайн мэдэх вэ? алхалтын уралдаан

- * Урлагийн наадам 5 багийн дунд

- * 3 төрлийн бүжгийн тэмцээн

Амьдрах орчноо сайжруулах хүрээнд

- * Өндөр настан хөгжлийн бэрхшээлтэй Бурмаагийн хашааг 480,000 төгрөгийн өртөгөөр шинэчлэн барьж өгөв.

- * Байгууллагын ахмад настан Чулуунбат ахын түлээг хөрөөдөж хурааж өгсөн ба хотруу эмчилгээнд явахад нь 50000 төгрөгийн тусламж дэмжлэг үзүүллээ.

Хатгал тосгонд “Хөх сувд 2019” мөсний баярын үеэр зохион байгуулагдсан “Алунгоо хатны үр сад” олон ястны урлаг соёлын наадамд амжилттай оролцож Урианхай ястны өв соёлыг гадаад, дотоодын жуулчдад сурталчлан хамтлагаараа мөнгөн медаль, урианхай харилцаа дуугаар Отгонбат, Дуламсүрэн нар алтан медаль, Түвшин баяр хөөмийгөөр хүрэл медаль тус тус хүртэв.



Дэлтэй цэнхэр жуулчны баазад аялаж буй дотоодын 38 жуулчидад, Эртний далай жуулчны баазад 56 гадаад дотоодын жуулчидад нутгийн өвөрмөц дэг жаягийг харуулсан урлагийн тоглолтоо тоглож аялагчдын талархалыг хүлээлээ



Анхаарал тавьсанд баярлалаа